

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/29/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn
	Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn
	Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

48090 Дундговь аймаг, Сайнцогтоо сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2022.04.23 № 19
таний _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ЧАГНААДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012020716

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,526,947.2</u>	<u>30,547,042.5</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,400.0	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,400.0	-
3121	Төгрөг	16,400.0	-
31213	Арилжааны банк дахь харилцах	16,400.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	29,510,547.2	30,547,042.5
351	Түүхий эд материал	314,280.0	455,280.0
35110	Тусгай зориулалттай материал	314,280.0	455,280.0
354	Хангамжийн материал	29,196,267.2	30,091,762.5
35410	Бичиг хэргийн материал	1,195,000.0	1,059,000.0
35420	Аж ахуйн материал	12,864,820.6	14,879,971.9
35440	Түлш, шатах тослох материал	4,227,300.0	4,884,680.0
35470	Бусад хангамжийн материал	10,909,146.6	9,268,110.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>234,961,943.6</u>	<u>207,142,622.1</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	234,961,943.6	207,142,622.1
392	Биет хөрөнгө	176,117,943.8	147,679,566.5
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,696,500.0	137,696,500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,982,938.5)	(94,868,466.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,728,572.5	316,101,700.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	(202,285,565.4)	(234,463,774.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,592,094.5	50,132,094.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,630,719.2)	(26,918,487.7)
393	Биет бус хөрөнгө	58,843,999.8	59,463,055.6
39301	Программ хангамж	1,680,000.0	2,450,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,636,000.2)	(1,786,944.4)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,800,000.0	58,800,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>264,488,890.8</u>	<u>237,689,664.6</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>264,488,890.8</u>	<u>237,689,664.6</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	264,488,890.8	237,689,664.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,529,981.9	162,529,981.9
51101	Өмч: - төрийн	162,529,981.9	162,529,981.9
512	Хуримтлагдсан үр дүн	100,515,036.3	73,715,810.1
51210	Өмнөх үеийн үр дүн	100,515,036.3	100,515,036.3
51220	Тайлант үеийн үр дүн	-	(26,799,226.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,443,872.6	1,443,872.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>264,488,890.8</u>	<u>237,689,664.6</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	791,451,657.4	550,375,551.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,641,157.4	108,654,751.7
120	Нийтлэг татварын бус орлого	315,641,157.4	108,654,751.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	315,641,157.4	108,654,751.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,308,010.7	71,183,066.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.0	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	94,313,060.0	30,683,128.0
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	49,020,086.7	6,788,556.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,810,500.0	441,720,800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,310,500.0	429,720,800.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	464,310,500.0	429,720,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,500,000.0	12,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,500,000.0	7,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	741,419,377.0	577,174,777.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,419,377.0	577,174,777.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,970,856.3	493,328,739.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,774,042.0	329,572,048.0
210101	Үндсэн цалин	206,280,683.0	221,681,069.0
210102	Нэмэгдэл	56,920,886.0	72,203,765.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,770,000.0	6,552,000.0
210104	Урамшуулал	22,142,724.0	18,205,314.0
210105	Гэрээт ажлын хөлс	14,659,749.0	10,929,900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,977,050.0	42,910,687.0
210201	Тэтгэврийн даатгал	26,573,897.0	29,866,569.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,126,340.0	3,299,749.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,480,912.0	2,629,720.8
210204	Ажилгүйдлийн даатгал	603,539.0	643,982.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,192,362.0	6,470,664.1
2104	Хангамж, бараа материалын зардал	59,963,574.7	19,588,815.5
210401	Бичиг хэрэг	2,393,000.0	3,732,800.0
210402	Тээвэр, шатахуун	9,271,540.0	6,851,480.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,948.0	846,630.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,214,420.0	2,600,834.5
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	45,283,666.7	5,557,071.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	652,000.0	920,000.0
210604	Урсгал засвар	652,000.0	920,000.0
2107	Томилолт, зочны зардал	2,453,500.0	12,108,400.0
210702	Дотоод албан томилолт	2,453,500.0	12,108,400.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,978,690.0	779,575.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,422,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	403,400.0	603,400.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,290.0	110,175.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.0	66,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,171,999.6	87,449,213.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,242,600.0	28,946,764.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,929,399.6	58,502,449.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,448,520.7	83,846,038.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,719,866.0	10,155,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	2,700,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,679,966.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,039,900.0	7,455,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	172,291,610.7	71,199,466.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,291,610.7	71,199,466.9
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,000,000.0	1,362,400.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.0	1,362,400.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,437,044.0	1,129,172.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,437,044.0	1,129,172.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>50,032,280.4</u>	<u>(26,799,226.2)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>50,032,280.4</u>	<u>(26,799,226.2)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	103,729,981.9	2,120,038.5	58,471,030.5	164,321,050.9
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	103,729,981.9	2,120,038.5	58,471,030.5	164,321,050.9
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(24,693,654.1)	(24,693,654.1)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,529,981.9	1,443,872.6	100,515,036.3	264,488,890.8
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,529,981.9	1,443,872.6	100,515,036.3	264,488,890.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,529,981.9	1,443,872.6	100,515,036.3	264,488,890.8
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(26,799,226.2)	(26,799,226.2)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,529,981.9	1,443,872.6	73,715,810.1	237,689,664.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	648,118,510.7	512,903,866.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	172,308,010.7	71,183,066.9
120	Нийтлэг татварын бус орлого	172,308,010.7	71,183,066.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	172,308,010.7	71,183,066.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,308,010.7	71,183,066.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,810,500.0	441,720,800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,310,500.0	429,720,800.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	464,310,500.0	429,720,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,500,000.0	12,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,500,000.0	7,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	648,102,110.7	512,920,266.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,102,110.7	512,920,266.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,653,590.0	429,074,228.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,774,042.0	329,472,585.0
210101	Үндсэн цалин	206,280,683.0	221,581,606.0
210102	Нэмэгдэл	56,920,886.0	72,203,765.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,770,000.0	6,552,000.0
210104	Урамшуулал	22,142,724.0	18,205,314.0
210105	Гэрээт ажлын хөлс	14,659,749.0	10,929,900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,977,050.0	43,010,150.0
210201	Тэтгэврийн даатгал	26,573,897.0	29,938,279.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,126,340.0	3,306,688.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,480,912.0	2,635,270.8
210204	Ажилгүйдлийн даатгал	603,539.0	645,369.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,192,362.0	6,484,541.1
2104	Хангамж, бараа материалын зардал	15,911,568.0	19,678,884.0
210401	Бичиг хэрэг	3,580,500.0	3,596,800.0
210402	Тээвэр, шатахуун	9,598,700.0	12,443,480.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,948.0	846,630.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,931,420.0	2,791,974.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	652,000.0	995,000.0
210604	Урсгал засвар	652,000.0	995,000.0
2107	Томилолт, зочны зардал	2,453,500.0	12,108,400.0
210702	Дотоод албан томилолт	2,453,500.0	12,108,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,978,690.0	779,575.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,422,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	403,400.0	603,400.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,290.0	110,175.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.0	66,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,906,740.0	23,029,634.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,906,740.0	23,029,634.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,448,520.7	83,846,038.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,719,866.0	10,155,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	2,700,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,679,966.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,039,900.0	7,455,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	172,291,610.7	71,199,466.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,291,610.7	71,199,466.9
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,000,000.0	1,362,400.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.0	1,362,400.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,437,044.0	1,129,172.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,437,044.0	1,129,172.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,400.0	(16,400.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,400.0	(16,400.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,400.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,400.0	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,720,800.00	428,591,628.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,720,800.00	428,591,628.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,545,800.00	421,436,628.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327,800,300.00	327,391,086.00
210101	Үндсэн цалин	219,724,400.00	219,500,107.00

210102	Нэмэгдэл	72,332,300.00	72,203,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,608,000.00	6,552,000.00
210104	Урамшуулал	18,205,700.00	18,205,314.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,929,900.00	10,929,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,830,300.00	42,729,149.00
210201	Тэтгэврийн даатгал	29,809,300.00	29,740,537.72
210202	Тэтгэмжийн даатгал	3,294,000.00	3,285,873.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,625,100.00	2,618,618.84
210204	Ажилгүйдлийн даатгал	642,800.00	641,206.73
210205	Эрүүл мэндийн даатгал	6,459,100.00	6,442,912.14
2104	Хангамж, бараа материалын зардал	18,009,400.00	17,981,284.00
210401	Бичиг хэрэг	3,602,900.00	3,596,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,746,000.00	10,745,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	864,000.00	846,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,796,500.00	2,791,974.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	995,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	995,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,935,500.00	8,530,900.00
210702	Дотоод албан томилолт	8,935,500.00	8,530,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	819,400.00	779,575.00
210803	Даатгалын үйлчилгээ	603,400.00	603,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	110,175.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23150900.00	23029634.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,150,900.00	23,029,634.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,175,000.0	7,155,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,175,000.00	7,155,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,700,000.00	2,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,475,000.00	4,455,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	429,720,800.00	428,591,628.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	429,720,800.00	428,591,628.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	429,720,800.00	428,591,628.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	16,400.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,000,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,000,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,637,600.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,081,499.0
210101	Үндсэн цалин	2,081,499.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	281,001.0
210201	Тэтгэврийн даатгал	197,742.0
210202	Тэтгэмжийн даатгал	20,815.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,652.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,163.0
210205	Эрүүл мэндийн даатгал	41,629.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,697,600.0
210402	Тээвэр, шатахуун	1,697,600.0
2107	Томилолт, зочны зардал	3,577,500.0
210702	Дотоод албан томилолт	3,577,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,362,400.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,362,400.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,000,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь эрхэм зорилгоо “Дундговь аймгийн газрын нөөцийг төлөвлөх, зурагжуулах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ талаар аймаг, сумын Засаг даргын шийдвэр гаргах түвшинд мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар газрыг зөв зохистой ашиглах, хамгаалах, газрын эдийн засгийн үр өгөөжийг иргэд, байгууллага, аж ахуйн нэгж хүртэх нөхцөлийг бүрдүүлэх. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн төлөв, хэрэгжүүлэх үе шатны зорилттой уялдуулан барилга, дэд бүтэц, хот байгуулалт, хот суурины ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө болон барилга байгууламжийн зураг төсөл, тэдгээртэй холбогдолтой судалгаа хийж, санал гаргах, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтын дүнд 603.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 16 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 582,418.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,824.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,076.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийгдэж нийт зардал 577,174.8 мянган төгрөг болсон. Нийт зардал 577,174.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,771.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатны материаллаг байдлын 70 хувиар буюу 4,040.2 мянган төгрөгөөр дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,799.2 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16.4	-	(16.4)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	29,510.5	30,547.0	1,036.5
Үндсэн хөрөнгө	234,961.9	207,142.6	(27,819.3)
Нийт хөрөнгө	264,488.9	237,689.7	(26,799.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	264,488.9	237,689.7	(26,799.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	264,488.9	237,689.7	(26,799.2)

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан 30,683.1 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан боловч 58,502.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлагнасантай холбоотой тус данс нь буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 237,689.7 мянган төгрөг болж 26,799.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 482,776.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 482,776.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43,842.5 мянган төгрөгөөр бууруулан 438,933.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээс 429,720.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 429,720.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.7 хувийг зарцуулж, 1,129.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 7,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,000.0 мянган төгрөг, нийт 12,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 2,081.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 281.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,697.6 мянган төгрөг, томилолт зочны зардалд 3,577.5 мянга төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 3,000.0 мянган төгрөг, нийт 10,637.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,362.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Техник хяналтын сангаас нийт 30,683.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснээс 1,540.0 мянган төгрөгийн тавилгыг бэлтгэн Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.4-т /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заасныг зөрчсөн байна;

2. Улсын хэмжээнд газрын кадастрын цахим системд шилжин иргэд, аж ахуйн нэгж, байгууллага газартай холбоотой бүх мэдээллээ egazar.gov.mn сайтаас бүрэн авах боломжтой болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2021 онд нийт 457,193.6 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 10,539.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зөрчсөн 7,767.2 мянган төгрөгийн дараах зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,201.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,343.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 217.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 12,641.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн зардлыг 99.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
2. Техник хяналтын сангаас 5,243.6 мянган төгрөгийн тээвэр шатахууныг үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулан, зардлыг давхардуулан тайлагнасныг тус тус залруулав.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд 5,343.1 мянган төгрөгийн залруулга хийлгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг журамд заасан хэмжээнээс 217.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг барагдуулах төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор төсвийн хөрөнгөөр нэвтрүүлэг бэлтгэсэн, Завхан аймгийн ГХБХБГ-т туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж 5,439.4 мянган төгрөгийн төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.
2. Ажилчдад олгосон дархлаа дэмжих, халдвар хамгааллын хэрэгслийг тушаал шийдвэргүйгээр бэлтгэн, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийж 2,327.8 мянган төгрөгийг зарцуулсан.
3. Бараа үйлчилгээний бусад зардлаас 4,874.0 мянган төгрөгийг ажилчдын эрүүл мэндийг дэмжих зардалд зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагуудыг хүргүүлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/											
д/ д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин	1	5,439.4					1.0	5,439.4		

	байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор төсвийн хөрөнгөөр нэвтрүүлэг бэлтгэсэн, Завхан аймгийн ГХБХБГ-т туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.										
2	Ажилчдад олгосон дархлаа дэмжих, халдвар хамгааллын хэрэгслийг тушаал шийдвэргүйгээр бэлтгэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан.	1	2,327.8					1.0	2,327.8		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Цалингийн зардлыг дутуу тайлагнасан.	1	99.5	1.0	99.5						
2	Техник хяналтын сангаас тээвэр шатахууныг үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулан, зардлыг давхардуулан тайлагнасан	1	5,243.6	1.0	5,243.6						
3	Бараа үйлчилгээний бусад зардлыг ажилчдын эрүүл мэндийг дэмжих зардалд зарцуулсан.	1	4,874.0					1.0	4,874.0		
4	Эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг журамд заасан хэмжээнээс 217,731.00 /Хоёр зуун арван долоон мянга долоон зуун гучин нэг/ төгрөгөөр хэтрүүлэн олгосон	1	217.7			1.0	217.7				
	Нийт зөрчлийн дүн	6	18,201.91	2.0	5,343.1	1.0	217.7	3.0	12,641.1	-	-